

Бакалаврын өдрийн хөтөлбөрийн элсэгчдэд зориулсан нийтлэг асуулт ба хариулт

Бакалаврын өдрийн хөтөлбөрийн бүртгэл хэзээ эхлэх вэ? Яаж бүртгүүлэх вэ?

- 2021 оны 04 дугаар сарын 15-аас 07 дугаар сарын 05-ны өдрийн 18:00 цаг хүртэл цахимаар буюу <http://elselt.mandakh.mn/> хаягаар Боловсролын үнэлгээний төвийн <http://www.eec.mn/> сайтруу нэвтэрдэг код, нууц үгээ ашиглан бүртгүүлнэ. Бүртгэлийн хураамж 5000 төгрөгийг төлж хэдэн ч хөтөлбөр, мэргэжил сонгож бүртгүүлэх боломжтой ба бүртгэлийн хураамжаа төлсөн тохиолдолд таны бүртгэл баталгаажихийг анхаараарай.

Хэдэн хөтөлбөр, мэргэжлээр элсэлт авах вэ?

- Манай сургууль бакалаврын өдрийн 14 хөтөлбөр, мэргэжлээр элсэлт авдаг. Та хөтөлбөр, мэргэжил бүрийн дэлгэрэнгүй мэдээлэл авах бол <http://elselt.mandakh.mn/Home/Profession> холбоос руу хандана уу.

Шинэ элсэгчид зориулсан ямар ямар хөнгөлөлт, тэтгэлэгүүд байдаг вэ?

А. Бакалаврын өдрийн хөтөлбөрийн элсэгчийн үндсэн шалгалт оноог харгалзан, эхний хичээлийн жилийн I улиралд ноогдох сургалтын төлбөрийг дараах хэмжээгээр хөнгөлнө. Үүнд:

№	Үндсэн шалгалтын оноо	Хөнгөлөлтийн хувь
1	700-ээс дээш оноотой бол	50%
2	650-699 оноотой бол	30%
3	600-649 оноотой бол	20%

Б. Элсэгч нь сургуулийн босго оноог хангасан бөгөөд Мандах ИС-иас зохион байгуулсан олимпиадууд бусад тэмцээнд амжилттай оролцсон бол сургуулиас олгосон суралцах эрхийн бичгийг үндэслэн шууд элсүүлэх бөгөөд заагдсан сургалтын төлбөрийн хөнгөлөлт эдэлнэ.

В. Элсэгч нь сургуулийн босго оноог хангасан бөгөөд боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас гаргасан хуваарийн дагуу зохион байгуулсан улсын болон аймаг, нийслэлийн хэмжээний математик, физик, англи хэл, нийгэм, мэдээлэл зүйн олимпиадад сүүлийн 2 жилд 1-3-р байрт шалгарсан бол олимпиадын комиссоос олгосон зохих батламжийг үндэслэн эхний хичээлийн жилийн I улирлын сургалтын төлбөрийн 10-30%-ийн хөнгөлөлттэй суралцах, 4-10-р байрт шалгарсан бол дараалал харгалзахгүй элсүүлнэ.

Г. Элсэгч нь сургуулийн босго оноог хангасан бөгөөд төрийн захиргааны байгууллагаас баталсан үндэсний болон олон улсын хэмжээний урлаг, спортын тэмцээн, уралдааны 1-3 байрт шалгарсан бол зохих батламжийг үндэслэн эхний хичээлийн жилийн I улирлын сургалтын төлбөрийн 10-20%-ийн хөнгөлөлт өгч, дараалал харгалзахгүй элсүүлнэ.

Элсэгч нь 2 ба түүнээс дээш хөнгөлөлт авах болзол хангасан тохиолдолд хөнгөлөлтийг давхардуулан олгохгүй бөгөөд хамгийн өндөр хувиар нь тооцож олгоно.

Сургалтын төлбөрөө хувааж төлөх боломжтой юу?

- *Тиймээ, та сургалтын төлбөрөө хувааж төлөх боломжтой. Элсэлтийн жагсаалтанд орж, хяналтын тоонд багтан тэнцсэн тохиолдолд элсэлтээ баталгаажуулахын тулд сургалтын төлбөрийн урьдчилгаа төлөх ба намар хичээл эхлэхээс өмнө 50%-ийг, 2 сарын 01-ээс өмнө та үлдэгдэл төлбөрийг төлөх боломжтой.*
-

Элссэний дараа хөтөлбөрөө солих боломжтой юу?

- *Ямар ч боломжгүй учраас та элсэлтийн бүртгэлд бүртгүүлэхэдээ хөтөлбөрүүдээ сайн судалж сонгоорой.*
-

ЭЕШ-гүй элсэх боломжтой юу ?

- *Элсэгч нь БСШУСЯ-ны Сайдын А/194 тоот тушаалаар дараах тохиолдолд ЭЕШ-гүй элсэх боломжтой. Үүнд:*
 1. Дээд боловсролтой, 2 дахь дээд боловсрол эзэмших иргэн
 2. Дипломын боловсролтой, тусгай мэргэжлийн дунд сургуулийг төгссөн иргэн
 3. Гадаад оронд ерөнхий боловсрол эзэмшсэн бол тухайн улс орнуудад нийтлэг хүлээн зөвшөөрөгддөг шалгалтын оноог, боловсролын үнэлгээний төвөөр дүйцүүлэн тооцуулж, дүйцүүлсэн батламж авсан иргэн
 4. Гадаад улсын ижил түвшний их сургуулиас шилжин суралцах иргэн
-

Бакалаврын өдрийн хөтөлбөрөөр хэдэн жил суралцах вэ?

- *Бакалаврын өдрийн хөтөлбөрөөр 4 жил суралцана.*
-

Төлбөр төлөх дансны дугаар?

- *Хаан банк 5087014563, гүйлгээний утганд регистрын дугаар, овог нэрээ бичнэ.*
-

Сургалтын төлбөр хэд вэ?

- *Сургалтын төлбөр хөтөлбөр бүрээр өөр өөр байдаг тул 70185950, 70185949 утсаар холбогдоно уу*
-

Мандах Их Сургууль хаана байрладаг вэ?

- *БГД, 16-р хороо, Амарсанаагийн гудамж 18/1, Баруун 4 зам Макс моллын хойно, Баруун 4 замаас модны 2 орох зам дагуу байрладаг.*